

1 ДҮГЭЭР ХЭСЭГ

Зөвлөмж: Сонгох хэлбэрийн даалгавар нь тус бүр 1 оноотой. Даалгаврыг анхааралтай уншиж, зааврын дагуу хийж гүйцэтгээд дөрвөн хариултаас зөв гэж бодсон нэг хариултыг сонгон дугуйлна уу. (*) тэмдэгтэй даалгавруудыг заавал дуу болон хөгжмийг сонссоны үндсэн дээр хийж гүйцэтгэнэ.

1. Дараах уран бүтээлүүд урлагийн ямар төрөлд хамаарч болохыг тодорхойлоод зөв хувилбарыг сонгоно уу.

1.



A.

Уран зураг

2.



B.

Бүжиг

3.



C.

Уран зохиол

4.



D.

Хөгжим

5.



E.

Театр

6.



F.

Кино

- Урлагийн төрлүүдийн илэрхийллийн аргад аль нь тохирох вэ? Сонгоно уу.

I.

Аялгуу,
хэмнэл

II

Үйл хөдлөл

III.

Гэрэл
сүүдэр, дүрс

IV.

Өнгө будаг,
дүрсийн
нийлэмж

V.

Уян
налархай
хөдөлгөөн

VI.

Уран үг

A.	1. F.III 2. D.II 3. E.I 4. B.III 5. A.IV 6. C.V	B.	1. E.VI 2. D.II 3. B.I 4. F.IV 5. A.III 6. C.V	C.	1. E.II 2. D.I 3. B.V 4. F.III 5. A.IV 6. C.VI	D.	1. E.VI 2. D.III 3. B.I 4. F.V 5. A.IV 6. C.II
----	--	----	---	----	---	----	---

2. Хэрвээ кино урлаг хөгжимгүй байсан бол ямар байх бол? Хөгжим, кино урлагт ямар үүргийг гүйцэтгэх вэ? Тохирохыг сонгоно уу.

- A. Киноны утга санаа, үйл явдал, гол дүрийн бодол санааг үзэгчдэд хүргэхэд хөгжим чухал үүрэгтэй. Өөрөөр хэлбэл үгээр илэрхийлэх боломжгүй зүйлийг хөгжмөөр дамжуулдаг.
- B. Киноны утга санаа, үйл явдал, гол дүрийн бодол санааг үзэгчдэд хүргэхэд хөгжмийн урлагийн гүйцэтгэх үүрэг чухал биш. Учир нь үйл явдлыг нүдээр харж, чихээр сонсоод ойлгож байгаа учраас.
- C. Киноны утга санаа, үйл явдал, гол дүрийн бодол санааг үзэгчдэд хүргэхэд хөгжим чухал үүрэгтэй ч дүрслэх урлаг ч бас өөрийн гэсэн үүргийг гүйцэтгэнэ.
- D. Киноны утга санаа, үйл явдал, гол дүрийн бодол санааг үзэгчдэд хүргэхэд урлагийн бүх төрлүүд өөрийн гэсэн онцлог үүргийг гүйцэтгэнэ.

3*. Ч. Лодойдамба "Шаргачин" өгүүллэгийн хэсгээс болон Б.Мөнхжаргал "Шаргачин" хөгжмийн бүтээлээс сонсоорой. <https://www.youtube.com/watch?v=Yuq87aY21cq>

Эхийгээ тойрон тонгочин тоглож буй янзаганы дүрийг ямар хөгжмийн зэмсгээр төлөөлүүлэн илэрхийлсэн байна вэ? Тохирох хувилбарыг сонгоорой.

A.



B.



C.



D.



4. Ноотоор аялж үзээд ямар дууны эхлэл хэсэг болохыг олоорой. Дууны эхлэл хэсгийг зохиогч болон нэртэй харгалзуулаарай.



- A. Ая. С.Батболд Шүл.Ш.Бадарч
"ГЭРЭЛТ НАРНЫ ХҮҮХДҮҮД"
- B. Ая. Т.Чимиддорж Шүл. Ө.Баасанжав
"НАРАА БАЯСАН УГТЪЯ"
- C. Ая. З. Хангал Шүл. Ш. Шажинбат
"ЭЭЖДЭЭ БИ ХАЙРТАЙ"
- D. Ая. С.Батболд Шүл. Д. Хүү
"МӨНХ ТЭНГЭРИЙН ОРОН"

A. 1D 2B 3A 4C

B. 1C 2D 3B 4A

C. 1B 2A 3C 4D

D. 1A 2C 3D 4B

5. Өгөгдсөн хэмнэлийг товшиж үзээд тохирох размерт /хэмжээ/ харгалзуулаарай



A. $\frac{4}{4}$



B. $\frac{2}{4}$



C. $\frac{3}{4}$ а

A. 1.A 2.B 3.C

B. 1.B 2.C 3.B

C. 1.B 2.A 3.C

D. 1.C 2.B 3.A

6. Вальс хөгжим хэдэн хувьт хэмжээнд бичигдэх вэ?

A. $\frac{2}{4}$

B. $\frac{3}{4}$

C. $\frac{4}{4}$

D. $\frac{5}{4}$

7*. Хөгжмийн бүтээлийг сонсоорой. Дуулаачийн аль төрөл байна вэ?

https://www.youtube.com/watch?v=d8qKyajRc_o

A.

B.

C.

D.

Кантат-Магтуу

Романс- Хүүрнэл дуу

Вокализ- Үггүй дуу

Дуу

8*. В.А.Моцарт "Турк марш" хөгжмийг сонсоод даалгаврыг гүйцэтгээрэй.

<https://www.youtube.com/watch?v=XCBI5kCbeNg>



а) Сонссон зохиолын айзам хэмжээнд аль нь тохирох вэ? Асуултын тэмдгийн оронд бичнэ үү.

A. $\frac{2}{4}$

B. $\frac{3}{4}$

C. $\frac{4}{4}$

D. $\frac{5}{4}$

б) Асуултын тэмдгийн оронд зохиолын хурдыг тодорхойлж бичнэ үү.

A. дунд зэрэг

B. хурдан

C. удаан

D. маш хурдан

в) Зохиолын сэдэв аялгууг ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдөж байна вэ? Тохирохыг сонгоно уу.



9*. Өгөгдсөн зохиолыг сонсоод найрал дууны ямар хэлбэрт дуулагдаж байгааг олоорой.

<https://www.youtube.com/watch?v=FPWYeXvnKls>


- A. холимог
- B. дан эмэгтэй
- C. хүүхдийн
- D. дан эрэгтэй

10*. Дараах бүтээлийг сонсоорой. Дан хөгжмийн ямар төрөл байна вэ?

<https://www.youtube.com/watch?v=uwY1KnJRYCo>

- A. симфони
- B. этюд
- C. концерт
- D. сюит

11. Ноот бичлэгийг ажиглаад аялгууны чиглэл хөдөлгөөнийг зөв харгалуулаарай.



- A. 1.д 2.в 3.а 4.б 5.г
- B. 1.д 2.г 3.в 4.б 5.а
- C. 1.б 2.д 3.а 4.г 5.в
- D. 1.а 2.б 3.г 4.д 5.в

2 ДУГААР ХЭСЭГ

Зөвлөмж: 2 дугаар хэсгийн даалгавруудыг сайтар уншаад хариултаа чөлөөтэй өгөх бөгөөд өөрийн хариултыг орхисон зай, дэвсгэр шугам, зурагт тэмдэглэнэ үү.

- 2.1. *а) П. Мусоргский “Хоёр еврей” хөгжмөөс сонсоорой. Урлагийн ямар төрөл, сэдэв агуулгын нөлөөгөөр туурвигдсан бэ? [1 оноо]

<https://www.youtube.com/watch?v=03qct-ORFfQ>

- A. Хөгжим – А.Гартман “Хоёр еврей” симфони
- B. Дүрслэх урлаг- А.Гартман “Хоёр еврей” уран зураг
- C. Уран зохиол - А.Гартман “Хоёр еврей” өгүүллэг
- D. Театр - А.Гартман “Хоёр еврей” дуурь

- б) “Хоёр еврей” зохиолын агуулга дүрийг хөгжмийн хэрэглүүрүүдээр хэрхэн илэрхийлсэн байна вэ? [5 оноо]

Аялгууны шинж төрх		Өнгө аяс		Регистр / Цар хүрээ /		Хүч		Зэмсэгжилт	
Баян	Ядуу	Баян	Ядуу	Баян	Ядуу	Баян	Ядуу	Баян	Ядуу

- 2.2. Эгшгийг нэрлэж ноотоор аялаарай. Чиний мэдэх ямар дуу байгааг бичнэ үү. [3 оноо]



.....

- 2.3. Ноотоор аялж үзээд дараах асуултад хариулаарай. [4 оноо]



- а) Аялгууны шинж төрх ямар байх вэ ?
- б) Өнгө аясыг хэрхэн илэрхийлэх вэ?
- с) Хурд болон хүчний нийлэмж ямар байх вэ?

.....

.....

.....

- 2.4. Ноот бичлэгийг ажиглаарай. Өгөгдсөн размер /хэмжээ/-т дөрөвт, наймт ноотыг хэрэглэн аялгууг гүйцээж бичээрэй. [2 оноо]



- 2.5. Дараах ноотуудыг ашиглан тэмээг дүрслэн 4 айзам (такт) аялгуу зохиогоорой. [4 оноо]



- 2.6. Өгөгдсөн дууны ноот бичлэгийг ажиглаарай. Үгийг зөв хуваарилан бичээд дуулаарай. [2 оноо]
 Үг. 3.Түмэнжаргал Ая. Б.Шарав

“ БАГШ ТА ”



Ганцхан миний ээжийнх гэмээр
 Халамж дүүрэн сэтгэлтэй та

- 2.7. а) Өгөгдсөн размерт (хэмжээ) айзмын зураасыг татаад, амьсгааны тэмдгийг байрлуулаарай. [1 оноо]



- 2.8. Ноот бичлэгийг ажиглаад дараах зааврын дагуу аялгуу зохиогоорой.
 а) Өгөгдсөн эгшгээс эхний айзмын аялгууны хөдөлгөөнийг дараагийн айзамд, 3 дах айзмын аялгууны хөдөлгөөнийг мөн дараачийн айзамд дахин давтаж бичээд үзээрэй. Энэ бол чиний зохиосон аялгуу болно. [1 оноо]



2.9 Өгөгдсөн түлхүүр үгсийг дуулаачийн болон дан хөгжмийн төрлөөр ангилаарай. [2 оноо]

реквием, концерт, сонат, оратори, сюит, баллада, романс, рапсоди, кантат, серенада,
ноктюрн, опера, этюд, вокализ, симфони, дуу.

Дуулаачийн хөгжим	Дан хөгжим